

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 12/370

НШУС

2011

СЭТГҮҮЛ ЗҮЙН СУРГАЛТЫГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОХ НЬ

Д.Ганчимэг*

* "Отгонтэнгэр" их сургуулийн сэтгүүл зүйн тэнхмийн багш, магистр, докторант

Түлхүүр үг: сэтгүүл зүйн сургалт, ОНМХ, сургалтын чиг хандлага, сургалтын шинэчлэл, боловсролын салбарын тулгамдсан асуудал, их дээд сургуулиуд

Орчин үеийн сэтгүүл зүйн тулгамдсан асуудлуудын нэг бол сэтгүүл зүйн сургалтыг боловсронгүй болгож, нийгмийн өнөөгийн шаардлагад нийцүүлэн сайжруулах явдал зүй ёсоор орж байна. Сэтгүүлч бэлтгэх асуудлыг амжилттай шийдвэрлэхгүйгээр "дөрөв дэх засаглал"-ын үүргийг гүйцэтгэж чадахуйц чөлөөт сэтгүүл зүйн тухай ярих боломжгүй юм. Тэгээд ч өнөөгийн сэтгүүлчдийн хэл ярианы болон бичин найруулах чадварт олон нийт ихээхэн шүүмжлэлтэй хандах болсон байна.

Түүнээс гадна орчин үеийн Монголын сэтгүүл зүйд дараах сөрөг үзэгдлүүд ажиглагдаж байна.

- Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд аль нэг нам хүчин, хэн нэгэн эрх мэдэлтэнд илт үйлчилдэг.

- Сэтгүүлчид авилга, хээл хахуульд өртдөг.

- Хэл ярианы чадвар сул.

- Бичиж найруулах авьяас дутмаг.

- Ямарваа нэг үйл явдлыг олон талаас нь дүгнэж, голч, бодит байр суурьнаас мэдээлдэггүй.

Бусад мэргэжлийг бодвол сэтгүүлч хүн үргэлж ард түмний төлөө дуугарч, олон түмний өмнө ил хөдөлмөрлөж

байдаг. Тиймээс мэргэжил, ур чадвараа үргэлж сайжруулж ахиж дэвшиж байх шаардлага тулгардаг.

Нийгмийн сэтгэл зүй, ёс суртахуун, ард түмний хүмүүжил төлөвшилд гарч буй сайн хийгээд саар үзэгдлүүдийг бүгдийг нь сэтгүүл зүй буюу хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хамтран үүрэлцэх учиртай болсон өнөө үед боловсрол судлалын шинжлэх ухаанд зориуд сэтгүүл зүйн салбарыг тусгайлан үзэх шаардлагатай болж байгаа юм.

Сэтгүүлч бэлтгэх үйл явцад баагүй саад бэрхшээл тулгарч түүнийг сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Сэтгүүлч бэлтгэж ирсэн арга барил дээр сэтгүүл зүйн хөгжил түүний орчин үеийн шинэ шинэ чиг хандлага, боловсон хүчнийг давтан бэлтгэх, мэргэжлийг нь дээшлүүлэх зэргээр шинэчлэл хийх шаардлага тулгарч байна. Нөгөөтэйгүүр ерөөс их дээд сургуулийн сургалтанд тулгамдаж буй зарим бэрхшээлүүд ч сэтгүүл зүйн сургалтанд нөлөөлж байгаа юм.

Дээд боловсролын систем ба сэтгүүл зүйн сургалт

Дээд боловсрол нь боловсролын шатлалын дээд хэлбэр юм. Энэ шатны боловсролын мөн чанар нь өмнөх шатныхтай харьцуулахад мэдлэг чадварыг эзэмших төдий бус, эзэмшсэнийгээ биежүүлэн хэрэглэх ур ухаантай болдогт оршино.

Дэлхий дахины дээд боловсролын салбарт хоёр чиг ханлага ажилгагдаж байна. Эхнийх нь дээд боловсролын глобалчлал буюу даяарчлал. Хоёр дахь нь дээд боловсролыг ардчилах буюу багш төвтэй сургалтаас шавь төвтэй сургалт руу шилжиж иргэд хүс-сэн мэргэжил сургууль, багшиг хүртэл чөлөөтэй сонгож, үзэх хичээлийн дараалал, цаг хугацааны хамаарал харьцангуй уян хатан байх явдал юм.

Даяарчлалын үйл явц бол соёл иргэншлийн янз бүрийн саад бэрхшээлийг даван туулж, нийгмийн оюуны, ахуйн, улс төрийн үйл ажиллагааны бүх төрлийн хэм хэмжээ, стандартыг тэгшигтэх зорилго агуулдаг. Энэ нь үйл явц болохын хувьд улс дамжсан соёл иргэншлийн харилцаа, харилцан нөлөөлөл, үнэт зүйлс оршин тогтоно хүчтэй болохыг чухалчилдаг.

Θ нөөдөр мэдээлэл тэр дундаа сэтгүүл зүйн мэдээллийн ач холбогдол эрс өсөн нэмэгдэж, түүнийг хүн төрөлхтний амьдралд энери, материин нэгэн адил үүрэг гүйцэтгэдэг язгуур ойлголт гэж үздэг болжээ. Түүнээс ХХI зууныг мэдээллийн эрин гэдгийг дэлхий дахинд аль хэдийнээ хүлээн зөвшөөрсөн билээ. Үүнд сэтгүүл зүй хэмээх нийгмийн институт онцгой үүрэг гүйцэтгэх болно. Энэ нь сэтгүүл зүй дэх даяарчлалтай шууд холбоотой. Орчин үед цахим сэтгүүл зүй энгийн үзэгдэл болж, иргэний сэтгүүл зүй орж ирж байгаа нь сэтгүүл зүйн сургалтанд өөрөөр хандаж, эрс өөрчлөлт хийх шаардлага тавьж байна. Нөгөө талаар дээд боловсролын системд гарч буй өөрчлөлт, түүний хөгжлийн чиг хандлага зөвхөн сэтгүүл зүйн төдийгүй бүх төрлийн сэргэлтийн агуулга, арга хэлбэр, субъектын үйл ажиллагаанд хүчтэй нөлөөлж байна. Энэ бүхэн дараах хэд хэдэн шалтгаантай шууд холбоотой. Үүнд:

- Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн өсөлт маш хүчтэй явагдаж, энэ нь хэвийн үйл ажиллагаа явуулахын тулд

ажиллагсдын 50-иас доошгүй хувь нь дээд боловсролтой байхыг шаардаж байна. Энэ үзэгдэл дээд сургуулийн тоо өсөн нэмэгдэхэд нөлөөлөх болжээ. Манай оронд сүүлийн хориод жилд 180 орчим их, дээд сургууль, коллеж бий болсны дотор 20 орчим дээд сургуульд сэтгүүлч бэлтгэж байна.

- Шинжлэх ухааны болон шинжлэх ухааны технологийн мэдээллийн өсөлт маш хурдтай явагдаж сүүлийн 10aad жилд хоёр дахин нэмэгджээ. Энэ нь тасралтгүй явагдах боловсрол, мэргэжил дээшлүүлэх, давтан бэлтгэх асуудлыг хурцаар тавьж байна. Харин манай орны сэтгүүл зүйн сургалтанд ийм хандлага одоохондоо сул байгааг хэлэх хэрэгтэй.

- Технологийн маш хурдтай өөрчлөлт мэргэжлийг өөрчлөх, мэргэжилтэнд эрс өөрөөр хандахад хүргэж байна. Хос мэргэжилтэй, нэг чиглэлийг дагнасан боловч өргөн хүрээний мэргэжилтэн бэлтгэх шаардлага гарлаа. Сэтгүүлч гэсэн ерөнхий нэрээр биш сэтгүүлч-эрх зүйч, сэтгүүлч-эдийн заасгч, сэтгүүлч-улс төрч гэх мэт чиглэл мөн сэтгүүл зүйн дотор нарийн мэргэшүүлэх, сэдэв чиглэлээр төрөлжүүлэн бэлтгэх нь орчин үеийн ОНМХ-ийн хэрэгцээ шаардлагад нийцэх болно. Өөрөөр хэлбэл бакалаврын боловсрол гэдэг бол цааш суралцах мэргэшсэн мэргэжилтэн болох үндсэн бааз буюу суурь мэдлэг нь болсон гэдгийг судлаачид, мэргэжилтэнүүд хэлж байна.

- Төрөл бүрийн шинжлэх ухааны зааг дээр хийгддэг эрдэм шинжилгээ, судалгааны ажил тэргүүн зэрэгт тавигддаг болсон өнөө үед сэтгүүл зүй судлалд ч эрс өөрөөр хандаж бусад шинжлэх ухаантай холбон судлах, тодорхой асуудлын хүрээнд гүнзгийрүүлэн судлах шаардлага гарч байна. Үүнийг ялангуяа магистр, боловсролын докторын сургалтанд түлхүү анхаарах, ирээдүйн багш судлаач бэлтгэхэд харгалзан үзэх хэрэгтэй.

- Биеийн ба оюуны хөдөлмөрийг автоматжуулахад чиглэсэн оюуны үйл

ажиллагааны хэрэгслүүд бий болж байна. Энэ нь шинийг санаачлагч, шинэчлэгч мэргэжилтэнүүдийн тоо өсөхөд нөлөөлж хэвлэл мэдээллийн хэрэгслийг компьютержүүлэх зөвхөн сэтгүүлч төдийгүй бусад янз бүрийн мэргэжилтнүүд ажиллах шаардлага гарч эхэлжээ. Тиймээс зөвхөн сэтгүүлч уран бүтээлч бус сэтгүүлч-зураглаач, сэтгүүлч-программ зохиогч, сэтгүүлч-менежер зэрэг хос мэргэжлээр сэтгүүлч бэлтгэх нь сэтгүүл зүйн сургалтын тулгамдсан асуудал болж байна.

Сэтгүүл зүйн сургалтанд тохиолдож буй зарим бэрхшээлүүд, түүнийг шийдвэрлэх арга зам

Өнөөдөр сэтгүүл зүйн сургалтанд тохиолдож буй зарим нийтлэг бэрхшээлийг тодорхой хүрээнд хөндөж, шийдвэрлэх оновчтой арга замыг олоход хувь нэмэр оруулах үүднээс сэтгүүл зүйн сургалт явуулж байгаа 13 сургууль, тэдгээрийн 25 багшийн дунд судалгаа явуулж, үүнийхээ хариултанд үндэслэн сургалт явуулахад эн тэргүүнд тохиолдож байгаа бэрхшээлүүдийг үндсэн гурван ангиллаар авч үзсэн юм. Үүнд:

1. Багшлах боловсон хүчиний хүндрэл бэрхшээл
2. Сургалтын материаллаг бааз, тоног төхөөрөмжтэй холбоотой бэрхшээл
3. Сэтгүүл зүйн чиглэлээр суралцаж буй оюутанд тохиолдож буй бэрхшээл.

Дээрх ерөнхий ангилал манай сургалтанд өдөр тутам тохиолдож байдаг хамгийн энгийнээс нарийн төвөгтэй хүндрэл бэрхшээлийг ч хамарч байна.

Судалгаанаас үзэхэд мэргэжлийн боловсон хүчиний асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэсэн нь харагдаж байна. Тухайлбал нийт багш нарын 84 хувь нь сэтгүүлч мэргэжилтэй, 16 хувь нь л бусад мэргэжлийнх байв. Гэвч энэ дүнгээс нэгэн эргэлзээтэй бодол төрж байгаа юм. Энэ судалгаанд хамрагдсан багш нарын дийлэнх хувь нь мэргэж-

лийнх байхад яагаад сэтгүүл зүйн тулгамдсан асуудлын нэгэнд тооцогдоод байна. Энэ бол хоёр талтай асуудал юм.

Нэгдүгээрт: сэтгүүл зүйн сургалтанд багшлах ур чадварын талаар, судалгаа шинжилгээ хэрхэн хийх талаар бараг дурсдаггүй. Өөрөөр хэлбэл, мэргэжлийн сэтгүүлч л бэлтгэхээс багш судлаач бэлтгэж байсан түүх үгүй юм.

Хоёрдугаарт: сэтгүүл зүй гэдэг практик давамгайлсан сургалтанд тулгуурладагаараа нилээд онцлог гэж хэлж болно. Гэвч энэ бол практикаа голлоод онолоо орхих гэсэн үг биш. Тэгвэл энэ бүхнийг яаж зохицуулах вэ? Үүнд нэг л хариу гарна. Юу гэвэл онолын мэдлэгтэй, практик дээр өөрөө ажиллах чадвартай боловсон хүчин л хэрэгтэй гэсэн үг. Тэгвэл сургуулиа онц дүнтэй төгссөн оюутан шууд багш болж чадах уу? Мөн үүний эсрэгээр 10-20 жил цэвэр практик дээр ажиллаж байгаад ирсэн шилдэг сэтгүүлч сайн багш болж чадах уу. Энэ хоёрт хоёуланд нь нэг нэг хүндрэл үүсдэг.

Дөнгөж сургуулиа төгссөн шинэхэн багш онолын асуудлаа төгс биш ч тодорхой хэмжээнд хэлээд өгдөг ч яг тэр ярьж байгаа зүйлээ практик дээр ашиглах, шилдэг жишээ татах, өөрөө үлгэрлэн дууриаж үзүүлэх гэх мэт чадвар дутдагаас түүний хичээл нэг л сонирхолгүй, амьд биш, явцуу хүрээнд болж өнгөрдөг байна. Тэгвэл практик туршлага сайтай багш онолоо бага зэрэг яриад л “би тэнд тэгж байсан, тэнд тийм явдал болж байсан” гэх мэт аар саархан зүйлээр оромдож цаг нөгцөөхөд хүрдэг байна. Манай судалгаанд хамрагдсан нэгэн сургуулийн сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч “Ямар ч мундаг сайн сэтгүүлчийг урьж авчран хичээл заалгахад эхний 4 цагийн хичээл ороод л ярих юм нь дуусчихдаг” хэмээн дурсаж байсанас жишээлж болохоор байна.

Үүнийг багш нарын 64 хувь нь сэтгүүл зүйн сургалтанд сэтгэл хангалааун бус байгаагаас харж болно. Ингэхээр

сэтгүүл зүйн тулгамдсан асуудлын нэгдүгээрт зайлшгүй багшийн асуудал орж байгаа юм.

Хоёрдугаар хүндрэл бэрхшээл нь материаллаг бааз, тоног төхөөрөмжтэй холбоотой асуудал хэмээн багш нар зүй ёсоор үзсэн юм. Энэ бол яах аргагүй тулгамдаад байгаа асуудал мөн. Учир юу гэвэл сэтгүүл зүй гэдэг практикт түшиглэх ёстойг дээр дурдсан. Тэгвэл сургууль нь өөрийн гэсэн сонин гаргадаггүй, сонирхогчийн ч хамаагүй камер байхгүй, зурагт приставка, зургийн аппарат, компьютер гэх мэт сэтгүүл зүйн сургалтанд зайлшгүй хэрэгцээтэй наад захын техник хэрэгсэл байхгүйгээс хичээл явуулахад нэн хүндрэлтэй болж зөвхөн танхимиин шугамаар шил шилийг нь харуулж суулгаад л багш онолдоод байхаас өөр аргагүй болдог байна. Ялангуяа сэтгүүл зүйн сургалтанд сүүлийн үед мультимедиа буюу нэвтрүүлгээ монтажлах, телевиз радиогийн сургалтын студид зайлшгүй яригдаж байна. Энэ сэтгүүлчийг дан ганц бичих биш өөрсдөө бүтээдэг, сэтгэдэг болоход хамгийн их тулгуур болно гэдгийг багш нар хүлээн зөвшөөрч байна.

Гэвч Улаанбаатарт үйл ажиллагаага явуулдаг сэтгүүл зүйн мэргэжилтэн бэлтгэж байгаа 18 их дээд сургуулиуд дотор ийм студитэй нь тал хувьд нь ч хүрэхгүй байна. Телевиз радиогийн мэргэжлийн болон сургалтын студи байгуулахад 1-рт зардал их, 2-рт эрсдэл ихтэй (эвдрэх магадлал өндөр), 3-рт багшлах мэргэжлийн хүн хэрэгтэй гэх мэт хүндрэлүүдээс болж сургуулиуд байгуулж чадахгүй байна.

Тэгвэл энэ бүхнийг хэрхэн шийдвэрлэх вэ?

Боловсролын яамнаас “Сэтгүүл зүйн сургалт явуулах гэж байгаа сургууль ийм ийм техник хэрэгслийг заавал бүрдүүлсэн байх ёстой” гээд хатуу заагаад өгчихвэл чанаргүй сургуулиуд ч олноороо элсэлт авахаа болино. Хичээл ч сонирхолтой үр өгөөжтэй явагдаж болох юм.

Судалгаанд оролцсон багш нар сэтгүүл зүйг сургалт хангалтгүй байгаа нь дараах шалтгаантай холбоотой гэж үзжээ:

- Сургуульд

- элсэн орж ирж байгаа оюутнуудын суурь мэдлэг тааруу

- Мэргэжлийн ном сурах бичиг ховор

- Гадаад хэлээр ном сурах бичиг ашиглаж чаддаггүй

- Сургалтын материаллаг бааз тааруу.

Эдгээр бэрх-

Сэтгүүл зүйн сургалтанд сүүлийн үед мультимедиа буюу нэвтрүүлгээ монтажлах, телевиз радиогийн сургалтын студид зайлшгүй яригдаж байна. Энэ сэтгүүлчийг дан ганц бичих биш өөрсдөө бүтээдэг, сэтгэдэг болоход хамгийн их тулгуур болно гэдгийг багш нар хүлээн зөвшөөрч байна.

»

шээлүүд хаанаас үүдэн гарав гэдгийг тунгаан үзвэл хэд хэдэн нөхцөл дурдаж болохоор байна. Жишээлбэл: элсэгчидтэй холбоотой хүндрэл нь ЕБС-ийн төгсөгчдийн мэдлэгийн төвшин доогуур, сургалтын чанар сул, мөн цаашилбал сэтгүүл зүйн мэргэжлээр элсэгчдээс авч байгаа элсэлтийн шалгалтыг үгүй болгон ерөнхий шалгалтаар шийддэг болсон юм.

Мөн мэргэжлийн ном сурах бичиг, гарын авлага ховор, гадаадын ном зохиол ашиглах чадвар дутмаг зэрэг дутагдлууд ажиглагдаж байна. Үүн дээр нэмж хэлэхэд сүүлийн үед хурцаар тавигдаж байгаа шавь төвтэй сургалт, сургалтын чөлөөтэй харилцан ярилцах хэлбэр, оюутны мэдлэгийг үнэлж дүгнэх, харилцан мэтгэлцүүлж

тэндээс шинэ санааг оюутнаас өөрөөр нь олуулах гэх мэт дэвшилттэй сургалтын арга барилуудыг ихэнх нь сургалтандаа хэвшил болгож чадаагүй байгаа нь сургалтын чанар үр дунд багагүй нөлөөлж байгаа юм.

Дүгнэлт

Өнөөдөр нийгмийн “дөрөв дэх засаглал”-ыг удирдан чиглүүлж гар бие оролцон авч явах сэтгүүлчдийг бэлдэж буй сургалтанд зайлшгүй тулгамдаад байгаа асуудлуудаас дурдахад ийм байна. Сайн боловсон хүчин бэлтгэснээрээ сургууль нь бахархаж сайн сургуулиараа улс нь бахархах ёстай. Сэтгүүл зүй, шилдэг сэтгүүлчидээрээ нийгэм үргэлж бахархаж, тэднээрээ дутагдаж явдаг юм. Эцэст нь энэ бүхнийг хэрхэн засан залруулах талаар цөөн хэдэн санаа байгаагаа дурдъя.

Сэтгүүл зүйн сургалтыг сайжруулж сэтгүүлч боловсон хүчинийг чанартай бэлтгэхэд дээрх асуудлууд чухал үүрэгтэй байхын хамт тухайн мэргэжлийн онцлогоос шалтгаалан дараах асуудлуудыг анхаарах шаардлагатай юм. Үүнд:

- Элсэгчдийн чанарыг сайжруулахын тулд мэргэжлийн өндөр ур чадвар, авьяас шаарддаг сэтгүүлч мэтийн мэргэжлүүдэд сургуулиуд ур чадварын давхар шалгалт авдаг болох.

- Мөн ур чадварын шалгалтыг сургуулиуд өөрсдийн онцлогт тохируулан агуулга, хэлбэр, бүтцийг өөрчлөх.

- Сэтгүүлчдийг хос мэргэжлээр бэлтгэх.

- Багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, давтан бэлтгэх, багшах боловсон хүчинийг оюутны ширээнээс эхлэн тусгай хөтөлбөрөөр бэлтгэх, магистр, докторын шаталсан сургалтанд хамруулах.

- Сургалтын материал техникийн баазыг эрс сайжруулах “сургалт+ судалгаат+үйлдвэрлэл”-ийн хоорондох харилцан уялдаа холбоо, тасралтгүй байх боломжийг хангах.

- Сэтгүүлч бэлтгэдэг их дээд сургуулиуд хоорондоо хамтран ажиллах, мөн практикийн байгууллагуудтай аль болохоор харилцан холбоотой ажиллах.

- Сургалт судалгааг өндөр төвшинд хосолж, багш нар төдийгүй оюутнуудыг сэтгүүл зүйн судалгаанд татан оролцуулах талаар онцгой анхаарах. Энэ нь оюутныг судалгаа хийх арга барил эзэмшиж, танин мэдэхүйн хүрээг өргөжүүлэхэд нөлөөлөхийн хамт ОНМХ-ийн сүл болон давуу талыг дутагдал дооголдлыг сайн мэдэх, бичиг чадварыг сайжруулах, онолын сэтгэлгээг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх болно.

- Сургуулиуд гадаад харилцаагаа хөгжүүлж хамтын ажиллагааг бэхжүүлэх, янз бүрийн төсөл хэрэгжүүлэх, тус дэмжлэг авах, багш оюутан солилцох зэрэг юм.

- Багш нарын ур чадварыг сайжруулахын тулд гадаадын олон оронд хэрэглэгддэг сэтгүүлч-багш гэсэн ойлголтыг төлөвшүүлж багш нарыг хэвлэлийн редакцид, сэтгүүлчдийг их дээд сургуулиудад гэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх.

- Сэтгүүлч мэргэжлээр тэгсэн гарч буй оюутнуудын өөрсдөө хийх, бүтээх оролдлогуудыг дэмжин оюутан-урган бүтээлч байх орчныг бүрдүүлж егехед сургууль тус бүр анхаарах.

- Сэтгүүл зүйн мэргэжлийн хичээлүүдийн хөтөлбөрт өөрчлөлт оруулж телевизийн хэл яриа, найруулгын уран чадвар болон нийгмийн ухааны хичээлүүдийн стандарт агуулгад хяналтавих.

Сэтгүүл зүй төрөл бүрийн шинжлэх ухаан, практик үйл ажиллагааны шинжийг өөртөө агуулсан өвөрмөц нийгмийн институт учраас түүний боловсон хүчинийг бэлтгэх асуудал үлэмж нарийн төвөгтэй, багагүй хүч хөдөлмөр, цаг хугацаа шаардах онцлогтой.

Үүнийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд цогц асуудалд анхаарлаа төвлөрүүлж үйгагүй эрэл хайгуул хийх онол практик, арга зүйн мэдлэгтэй, дадал

чадвар эзэмшиж, тодорхой туршлага хуриатлуулсан байх шаардлагатай юм. Энэ бүхэн өнөөгийн сэтгүүл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хөшүүрэг болж өгөх юм.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. 1999. Сэтгүүлчийн уран чадварын тухай яриа. УБ.
2. Баасансүрэн Т. 2002. Сэтгүүлчийн уран чадварын асуудал уламжлал ба шинэчлэл. УБ.
3. Жамц Л., Даааа Ж., Содов Ц., Сүхбат Г. 2011. Боловсрол судлалын үндэс. УБ.
4. Зулькафиль М. 1995. Өөрчлөлт шинэчлэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл. УБ.
5. Зулькафиль М. 2007. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ.
6. Зулькафиль М. 2010. Монголын олон нийтийн мэдээлэл: нэг намын үзэл сурлаас олон ургальч үзэл хүртэл. УБ.

7. Зулькафиль М. 2011. Ардчилсан нийгэм дэх сэтгүүл зүйн онол, практикийн асуудлууд // Монголын шилдэг нийтлэл, №31, УБ.

8. Норовсүрэн Л., Энхтуяа Х. 2005. Иргэний сэтгүүл зүй. УБ.

9. 1993. Олон нийтийн мэдээлэл ба ардчилал. УБ.

Резюме

В статье автор затронула некоторые проблемы, которые оказывают отрицательное влияние на развитие монгольской журналистики и предприняла попытку выявления причин негативного отношения аудитории к журналистам. Как считает автор, нынешняя проблема исходит из патовой ситуации, в которой оказалось журналистское образование. Автор предлагает пути выхода из этой ситуации.